

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-агт сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/153/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Булган аймаг 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 70342580 Цахим хаяг: Ankhubayard@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: П.Содном Утас: 70342495 Цахим хаяг: Sodnomp@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-3259
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 51

танай _____ ны № _____ т

БЯАН-АГТ СУМЫН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Д.ОТГОНЦЭЦЭГ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Баян-Агт сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Агт сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D:/bichighereg/2022A4toot

• 006020051

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>60,840,088.84</u>	<u>66,820,233.29</u>
33	АВЛАГА	6,000,000.00	-
335	Бусад авлага	6,000,000.00	-
3351	Байгууллагаас авах авлага	6,000,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	54,840,088.84	66,820,233.29
354	Хангамжийн материал	54,840,088.84	66,820,233.29
35410	Бичиг хэргийн материал	2,150,100.00	1,827,950.00
35420	Аж ахуйн материал	50,721,856.04	61,510,426.04
35460	Хүнсний материал	1,968,132.80	3,481,857.25
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>373,429,807.33</u>	<u>363,561,200.43</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	373,429,807.33	363,561,200.43
392	Биет хөрөнгө	362,715,807.33	353,100,325.43
39201	Барилга, байгууламж, орон сууц	329,810,000.00	329,810,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(22,449,793.50)	(33,252,576.57)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	46,723,364.00	53,604,654.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(19,839,617.80)	(26,423,786.59)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	48,400,952.86	53,100,952.86
39208	Хуримтлагдсан элэгдэл	(25,548,775.23)	(29,548,595.27)
39217	Ном	5,619,677.00	5,809,677.00
393	Биет бус хөрөнгө	10,714,000.00	10,460,875.00
39301	Програм хангамж	1,350,000.00	1,350,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(253,125.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	9,364,000.00	9,364,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>434,269,896.17</u>	<u>430,381,433.72</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>125,004.22</u>	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	125,004.22	-
413	Өглөг	125,004.22	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	125,004.22	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>434,144,891.95</u>	<u>430,381,433.72</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	434,144,891.95	430,381,433.72
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	95,616,502.48	95,616,502.48
51101	Өмч: - төрийн	95,616,502.48	95,616,502.48
512	Хуримтлагдсан үр дүн	(15,748,063.31)	(19,511,521.54)
51210	Өмнөх үеийн үр дүн	(15,748,063.31)	(15,748,063.31)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(3,763,458.23)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	354,276,452.78	354,276,452.78
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>434,269,896.17</u>	<u>430,381,433.72</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
			/Төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	414,247,095.00	319,822,840.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,431,095.00	7,992,040.00
120	Нийтлэг татварын бус орлого	10,891,795.00	7,992,040.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,891,795.00	7,992,040.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	10,891,795.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө		5,011,590.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал		2,980,450.00
122	Тусламжийн орлого	2,539,300.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	2,539,300.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	400,816,000.00	311,830,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	337,071,600.00	256,448,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	337,071,600.00	256,448,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	200,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	63,744,400.00	55,182,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	63,744,400.00	55,182,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	423,682,953.72	323,586,298.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	423,682,953.72	323,586,298.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	350,126,908.10	303,444,246.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	188,473,722.63	187,021,173.00
210101	Үндсэн цалин	133,243,555.83	134,122,995.00
210102	Нэмэгдэл	39,151,487.80	37,010,017.00
210104	Урамшуулал	16,078,679.00	15,888,161.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,237,337.04	24,340,570.60
210201	Тэтгэврийн даатгал	19,117,063.64	17,289,836.32
210202	Тэтгэмжийн даатгал	2,280,507.07	1,585,629.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,824,265.65	1,889,239.25
210204	Ажилгүйдлийн даатгал	454,587.55	319,633.32
210205	Эрүүл мэндийн даатгал	4,560,913.13	3,256,232.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,036,540.00	54,382,400.00
210301	Гэрэл, цахилгаан	1,708,212.00	1,253,301.00
210302	Түлш, халаалт	59,193,328.00	52,919,099.00
210303	Цэвэр, бохир ус	135,000.00	210,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,700,753.30	3,012,799.25
210401	Бичиг хэрэг	502,600.00	317,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,265,000.00	1,264,999.25
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	492,000.00	437,000.00
210404	Ном, хэвлэл	47,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,252,700.00	910,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,139,000.00	82,800.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	423,000.00	-
210408	Бараа материал акталсны зардал	21,579,453.30	-
2105	Нормативт зардал	16,180,767.00	7,499,275.55
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	49,200.00	27,800.00
210502	Хоол, хүнс	15,730,067.00	6,450,775.55
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	401,500.00	1,020,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	145,500.00	-
210604	Урсгал засвар	145,500.00	-

Баян-Агт сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	388,000.00	99,100.00
210702	Дотоод албан томилолт	388,000.00	99,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	734,000.00	154,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	518,000.00	154,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,230,288.13	26,934,827.65
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,130,700.00	3,276,480.75
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,433,000.00	2,018,450.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	23,666,588.13	21,639,896.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	73,556,045.62	20,142,052.18
2132	Бусад урсгал шилжүүлэг	581,000.00	600,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	581,000.00	600,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	72,975,045.62	19,542,052.18
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	72,975,045.62	19,542,052.18
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(9,435,858.72)	(3,763,458.23)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	22,575,352.35	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	22,575,352.35	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(22,575,352.35)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(32,011,211.07)	(3,763,458.23)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	95,616,502.48	354,276,452.78	(5,726,814.32)	444,166,140.94
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	95,616,502.48	354,276,452.78	(5,726,814.32)	444,166,140.94
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	(12,491.22)	(12,491.22)
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(10,008,757.77)	(10,008,757.77)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	95,616,502.48	354,276,452.78	(15,748,063.31)	434,144,891.95
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	95,616,502.48	354,276,452.78	(15,748,063.31)	434,144,891.95
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	95,616,502.48	354,276,452.78	(15,748,063.31)	434,144,891.95
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(3,763,458.23)	(3,763,458.23)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	95,616,502.48	354,276,452.78	(19,511,521.54)	430,381,433.72

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	401,323,750.00	312,581,550.00

Баян-Агт сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	507,750.00	750,750.00
120	Нийтлэг татварын бус орлого	507,750.00	750,750.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	507,750.00	750,750.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	507,750.00	750,750.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	400,816,000.00	311,830,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	337,071,600.00	256,448,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	337,071,600.00	256,448,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	200,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	63,744,400.00	55,182,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	63,744,400.00	55,182,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	388,175,750.00	305,821,850.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	388,175,750.00	305,821,850.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	314,619,704.38	285,679,797.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	188,022,277.34	187,146,177.22
210101	Үндсэн цалин	132,792,110.54	134,247,999.22
210102	Нэмэгдэл	39,151,487.80	37,010,017.00
210104	Урамшуулал	16,078,679.00	15,888,161.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,237,337.04	24,340,570.60
210201	Тэтгэврийн даатгал	19,117,063.64	18,480,696.32
210202	Тэтгэмжийн даатгал	2,280,507.07	1,585,629.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,824,265.65	698,379.25
210204	Ажилгүйдлийн даатгал	454,587.55	319,633.32
210205	Эрүүл мэндийн даатгал	4,560,913.13	3,256,232.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,423,940.00	54,382,400.00
210301	Гэрэл, цахилгаан	2,020,612.00	1,250,000.00
210302	Түлш, халаалт	59,193,328.00	52,922,400.00
210303	Цэвэр, бохир ус	210,000.00	210,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,584,100.00	4,605,900.00
210401	Бичиг хэрэг	500,000.00	462,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,265,000.00	1,265,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	467,000.00	467,000.00
210404	Ном, хэвлэл	54,600.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,061,300.00	2,221,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,236,200.00	189,800.00
2105	Нормативт зардал	17,760,650.00	9,227,250.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	49,200.00	48,800.00
210502	Хоол, хүнс	17,266,950.00	8,715,250.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	444,500.00	463,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	800,000.00	800,000.00
210604	Урсгал засвар	800,000.00	800,000.00
2107	Томилолт, зочны зардал	388,000.00	99,100.00
210702	Дотоод албан томилолт	388,000.00	99,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	708,300.00	446,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	492,300.00	446,700.00

Баян-Агт сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,695,100.00	4,631,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,074,100.00	3,027,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,621,000.00	1,603,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	73,556,045.62	20,142,052.18
2132	Бусад урсгал шилжүүлэг	581,000.00	600,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	581,000.00	600,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	72,975,045.62	19,542,052.18
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	72,975,045.62	19,542,052.18
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	13,148,000.00	6,759,700.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	13,148,000.00	6,759,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,148,000.00	6,759,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	13,148,000.00	6,759,700.00
222001	Тоног төхөөрөмж	13,070,000.00	1,869,700.00
223001	Бусад хөрөнгө	78,000.00	4,890,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(13,148,000.00)	(6,759,700.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		
21	УРСГАЛ ЗАРДАЛ		
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		
210101	Үндсэн цалин	139990000.00	134247999.22
210102	Нэмэгдэл	41650700.00	37010017.00
210104	Урамшуулал	17200000.00	15888161.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		
210201	Тэтгэврийн даатгал	19624900.00	18480696.32
210202	Тэтгэмжийн даатгал	2090400.00	1585629.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	1578700.00	698379.25
210204	Ажилгүйдлийн даатгал	407700.00	319633.32
210205	Эрүүл мэндийн даатгал	4076700.00	3256232.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		
210301	Гэрэл, цахилгаан	1250000.00	1250000.00
210302	Түлш, халаалт	52922400.00	52922400.00
210303	Цэвэр, бохир ус	210000.00	210000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		
210401	Бичиг хэрэг	500000.00	499700.00
210402	Тээвэр, шатахуун	1265000.00	1265000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	467,000.00	467,000.00
210404	Ном, хэвлэл	52,300.00	52,300.00

Баян-Агт сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,022,000.00	2,021,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,059,500.00	2,059,500.00
2105	Нормативт зардал	12,884,800.00	9,227,250.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	48,800.00	48,800.00
210502	Хоол, хүнс	12,372,800.00	8,715,250.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	463,200.00	463,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,500,000.00	5,500,000.00
210602	Тавилга	4,700,000.00	4,700,000.00
210604	Урсгал засвар	800,000.00	800,000.00
2107	Томилолт, зочны зардал	99,100.00	99,100.00
210702	Дотоод албан томилолт	99,100.00	99,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	446,700.00	446,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	446,700.00	446,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,732,900.00	4,732,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,027,900.00	3,027,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,705,000.00	1,704,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	600,000.00	600,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	600,000.00	600,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	600,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	311,630,800.00	312,381,550.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	256,448,400.00	256,448,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	256,448,400.00	256,448,400.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	55,182,400.00	55,182,400.00
132001	Орон нутгийн төсвөөс	55,182,400.00	55,182,400.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	750,750.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		750,750.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	200,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	200,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	200,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	200,000.00

II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	200,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	200,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баян-Агт сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд анхан шатны баримтын бүрдлийг хангах, авлага, өглөг үүсгэхгүй байхгүй, анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгө холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор П.Содном гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Баян-Агт сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 09/01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баян-Агт сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны үйл ажиллагаа, гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө 7 зорилтын хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Үүнд:

1. Хүүхэд хөгжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд
2. Хууль эрх зүйг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн цэцэрлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлж, сэргээн засах үйлчилгээг нийгэм хамт олонд нь түшиглэн тогтмол үзүүлнэ.
4. Цахим сургалтын платформыг хөгжүүлэх, цахим агуулга, цахим хичээл боловсруулж, бүх насны иргэдийн Насан туршийн боловсрол"-ыг дэмжинэ.
5. Хүүхдийг эрүүл, илчлэг сайтай хоол хүнсээр хангах
6. Төсөв санхүүгийн зөв зарцуулалт, сахилга хариуцлага
7. Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хүрээнд гэсэн нийт 22 арга хэмжээг хэрэгжүүлж 82.6 хувийн биелэлттэй байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баян-Агт сумын хүүхдийн цэцэрлэгийн бүтэц орон тоонд дотоод аудит байхгүй бөгөөд дээд шатны төсөв захирагчийн санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтэс 2021 онд төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян-Агт сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн нийт зардлын 424.6 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 6.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 7.5 хувиар буюу 4.8 сая төгрөгөөр тогтоосон.

Өмнөх оны үр дүнгийн зардал 101.0 сая төгрөгөөр буурсан тул тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатны материаллаг байдлын түвшинг 2021 оны үр дүнгийн нийт зардлын 323.6 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 4.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 7.5 хувиар буюу 3.6 сая төгрөгөөр тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баян-Агт сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3.8 сая буурсан нь тайлант оны элэгдэлтэй холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/Мян.төг /
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урьдчилж гарсан зардал			
Авлага	6000.0		-6000
Бараа материал	54840.1	66820.2	11980.1
Үндсэн хөрөнгө	441267.9	453039.3	11771.4
Нийт хөрөнгө	434269.9	430381.4	-3888.5
Өглөг	125.1		-125.1
Хуримтлагдсан үр дүн	-15748.1	-19511.5	-3763.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	434269.9	430381.4	3888.5

Авлага: Тайлант оны эхэнд Битаачи ХХК-аас авах 6.0 сая төгрөгийн тоглоомын авлагыг барагдуулж тайлант онд шинээр авлага үүсээгүй үлдэгдэлгүй тайлагнасан байна.

Бараа материал: Бараа материалын оны эхний үлдэгдэл 54.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 601.7 сая төгрөг болж өмнөх оноос 11.9 сая төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд 27.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 18.8 сая төгрөгийн бараа материал худалдан авч, өмнөх оны авлагаар тусгасан 6.0, дээд шатны байгууллагаас үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 2.9 сая төгрөгийн материал тус тус нэмэгдэж орлогоор тусгасан байна.

Нийт 15.8 сая төгрөгийн бараа материал хасагдсанаас 15.0 сая төгрөг зарцуулж, хорио цээртэй холбоотой үйл ажиллагаа явуулахгүй байгаатай холбоотой хүнсний үлдэгдлээс 0.8 сая төгрөгийн хүнс худалджээ.

Үндсэн хөрөнгө: Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 441.3 сая, эцсийн үлдэгдэл 453.1 сая төгрөг болж өмнөх оноос 11.8 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 6.8, дээд шатны төсөв захирагчаас үнэ төлбөргүй шилжиж ирсэн 5.0 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, тайлант онд шилжүүлсэн болон акталж данс бүртгэлээс хассан хөрөнгө байхгүй байна.

Өр төлбөр: Өглөг дансны оны эхний ХХОАТ-ын өглөгийн 0.1 сая төгрөгийн барагдуулж эцсийн үлдэгдэлгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 3116.3 сая төгрөгийн төсөв баталснаас 256.4 сая төгрөгийг улсын төсвөөс 55.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 3116.3 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагдаж, нийт зардлын 256.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 55.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 256.4, орон нутгийн төсвөөс 55.2 сая, хүнс худалдсаны 0.8 сая нийт 312.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 292.8 мянган төгрөгийг зарцуулж 19.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 292.8 сая төгрөг буюу 93.97 хувьтай байгаа нь цалин түүнтэй адилтгах зардал 11.7, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 3.4, нормативд зардал 3.7 сая төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсөв захирагчаас ариутгал халдвар хамгааллын хэрэгсэлд зориулж 0.2 сая төгрөгийн санхүүжилт олгож хог хаягдал зайлуулах зардал зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал буюу Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой дараах асуудлууд байна. Үүнд:

- Тус байгууллага 2021 оны батлагдсан төсөвт зардлын 6.0 хувиар буюу 18.8 мянган төгрөгийн хэмнэлт гаргаж ажилласан,
- Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээний батлагдсан төсөвт хэмнэлт гараагүй.

3.8 Аудитын гол асуудал

Тайлан үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар “Шилэн дансны тухай”, Засгийн газрын 2014 оны 384 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай” журмын дагуу шилэн дансны цахим хуудсанд нийт 146 мэдээлэл оруулахаас хугацаа хоцроосон мэдээлэл

байхгүй, хугацаанд нь оруулсан 146 мэдээг мэдээлсэн боловч цахим хуудасны хөтлөлтийн чанар байдлыг үзвэл төсөв, өмч хөрөнгөтэй холбоотой тушаал шийдвэр, таван сая төгрөгөөс дээш орлогын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй 40 нэр төрлийн 14231150.86 төгрөгийн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийг дахин үнэлээгүй тайланд тусгасан нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын хорооны 271 тоот тогтоолоор баталсан 7.1-д заасан "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийг ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шилэн дансны цахим хуудсанд төсөв, өмч хөрөнгөтэй холбоотой тушаал шийдвэр, таван сая төгрөгөөс дээш орлогын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" 6.4.5-д "6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8-д "...төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар нийт 523,900.4 мянган төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс, 1,350.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 2,096.1 мянган төгрөгийн 1 төлбөрийн актыг улсын төсөвт төвлөрүүлэхээр тогтоож, 72,424.4 мянган төгрөгийн зөрчилд таслан зогсоох 3 албан шаардлага өгч, 432,919.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн байна.

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт			Зөрүү	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь	Тоо	Дүн
Төлбөрийн акт	1	2096.1	1	2096.1	100	-	-
Албан шаардлага	3	72424.4	3	72424.4	100.0	-	-
Зөвлөмж	3	432919.9	3	432919.9	100.0	-	-
Нийт дүн	7	523900.4	7	523900.4	100.0	-	-

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар байгууллагад биет хөрөнгийн тооллого хийгээгүй, хөрөнгийн хадгалалт хамгаалалтын талаар дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 23.0 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс, 0.4 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 1.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн актыг тогтоож, 6.7 мянган төгрөгийн зөрчилд таслан зогсоох 2 албан шаардлага өгч, 14.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн байна.

4.1 Залруулсан алдаа

Худалдан авсан 410.0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр бүртгэснийг НББ-ийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна." 15.2 дахь "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна." гэсэн заалтын дагуу залруулга хийсэн.

4.2 Төлбөрийн акт

Бараа материалын жилийн эцсийн тооллогоор 1452245 төгрөгийн хүнсний материал дутагдуулсан байна. Энэ нь санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, тохиолдсон байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн байдал: Төлбөрийн акт тогтоосон.

4.3 Албан шаардлага

Тайлант онд 6759700 төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн нь ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4-д "энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх;" гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн байдал: Албан шаардлага өгсөн.

Шилэн дансны цахим хуудсанд төсөв, өмч хөрөнгөтэй холбоотой тушаал шийдвэр, таван сая төгрөгөөс дээш орлогын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" 6.4.5-д "6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8-д "...төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн байдал: Албан шаардлага өгсөн.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд нийт 0.2 сая төгрөгийн худалдан авалт И-баримтаар баталгаажуулаагүй, анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй байна.

Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйл 17.3.2-д "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно", Сангийн сайдын 2017 оны 347 тушаалын хавсралтад "5 Төлбөрийн баримт НХМаягт төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Худалдан авалт хийхдээ тухай бүр нь цахим И-баримтыг хангуулан бүртгэлд тусгаж байх.

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой

3.1 Илрүүлэлт:

Байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 40 төрлийн 14.2 сая төгрөгийн хөрөнгүүдийг дахин үнэлээгүй, данс бүртгэлээс хасаагүй тайланд тусгасан байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын хорооны 271 тоот тогтоолоор баталсан 7.1-д заасан "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийг ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Элэгдлийн нийт хэмжээ ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох болон данс бүртгэлээс хасах арга хэмжээ авч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баян-Агт цэцэрлэг	6	23.0	1	0.4	1	1.5	2	6.7	2	14.2
	Нийт дүн	3	8.4					1	0.5	2	7.9